

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

“Гермес Центр” ХКомпани нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт барилгын материалын Гермес худалдааны төвийг ажиллуулдаг билээ.

Тус компани нь 2019 оны эхний хагас жилд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Компанийн нийт ажиллагсадтай 2019 онд хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулж, ажиллагсдын ажлыг “Ажилтны үнэлгээний хуудас”-аар сар тутамд дүгнэж байна.
2. Компанийн ажиллагсдад сар тутам хурал хийж, мэдээ мэдээллийг танилцуулан, харилцан зөвшилцөх зарчмаар ажлаа явуулж байна.
3. Барилгын материалын Гермес худалдааны төв нь давхардсан тоогоор 200 гаруй түрээслэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй түрээсийн гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Тус худалдааны төвийн түрээслэгчдийг даатгалд бүрэн хамруулсан.
4. Түрээслэгчдэд сар бүр тогтмол захидал хүргүүлж байна. Түрээслэгчдийн зүгээс тавьсан санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж байна.
5. Арилжааны банк, даатгалын байгууллагуудтай хамтран уулзалт өдөрлөгийг түрээслэгчдийн дунд зохион явууллаа. Үүнд: ХХБ, Хаан банк, Голомт банк, Капитрон банк, Монгол даатгал, Мандал даатгал, Миг даатгал, Соембо даатгал гэх мэт
6. Онцгой байдлын ерөнхий газраас орон даяар зохион байгуулсан гамшгийн үед зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтанд худалдааны төвийн түрээслэгчид, ажиллагсдыг бүрэн хамрууллаа.
7. Аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Баянгол дүүргийн 4-р хорооны цагдаатай хамтран ажиллаж байна. Хорооны цагдаа хулгай, залилан, гэмт халдлагаас урьдчилан сэргийлж ажиллах талаар манай худалдааны төвийн түрээслэгчдэд зөвлөмж өгч заншлаа.
8. Худалдааны төвийн барилга байшин, хашаа хороонд өдөр тутмын жижиг урсгал засварын ажлуудыг байнга хийж байна.
9. Компанийн веб сайтад мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж байна
10. Манай компани нь 2019 онд дараах банк болон харилцагч байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүнд:
 - “Санхүүгийн зохицуулах хороо”
 - “Монголын хөрөнгийн бирж” ХК
 - “Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК
 - “Хаан банк”
 - “Голомт банк”
 - “Худалдаа хөгжлийн банк”
 - “Монгол даатгал” ХХК
 - “Ритус” ХХК
 - “Цэсб-аудит” ХХК
 - “Цагаан бар секьюритис” ХХК
 - “Датаком” ХХК
 - “Мобинет” ХХК
 - “Үндэсний дата төв” УТҮГазар
 - “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК
 - “УБЦТСүлжээ” ТӨХК

- “УБ хотын ОСНААУГ”
 - “Нийслэлийн газрын алба”
 - “Баянгол шинэ өргөө” ОНӨААТҮГ
 - “Баянгол дүүргийн татварын хэлтэс”
 - “Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс”
 - “Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс”
11. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлыг холбогдох хууль журмын дагуу 2019 оны 03-р сарын 07-ны өдөр хуралдуулж, хурлын материалыг тогтоосон хугацаанд СЗХороо, МХБиржид хүргүүлсэн.
12. Татварын байгууллагад төлөх ёстой татвараа хугацаанд нь төлж байна. Баянгол дүүргийн татварын хэлтсээс хийсэн ээлжит санхүүгийн шалгалтанд хамрагдлаа.

Санхүүгийн байдлаар талаарх мэдээлэл:

1. “Гермес Центр” ХКомпанийн санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүдийг танилцуулахад нийт хөрөнгө 8 546.9 сая төгрөг. Үүнээс:
- Эргэлтийн хөрөнгө 1 938.3 сая төгрөг
 - Эргэлтийн бус хөрөнгө 6 608.7 сая төгрөг
 - Эзэмшигчийн өмч хөрөнгө 8 337.6 сая төгрөг
 - Тайлант үеийн цэвэр ашиг 481.3 сая төгрөг байна.
2. Татварын өр төлбөрийн тухай :

Манай компани нь 2019 оны эхний хагас жил улсад 180.1 сая төгрөгийн татварыг төлөөд байна. Үүнд:

- ААН-ийн ОАТатварт 50.7 сая төгрөг,
- Ажиллагсдын цалингаас суутгасан хувь хүний ОАТатварт 9.4 сая төгрөг,
- НДШимтгэлд 28.5 сая төгрөг,
- НӨАТатварт 61.6 сая,
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 24.0 сая төгрөг,
- Газрын татварт 5.9 сая төгрөг

3. Орлогын үр дүнгийн тухай :

Манай компани 2019 оны эхний хагас жилд 704.7 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, хадгаламжийн хүүний 190.8 сая төгрөгийн орлоготой ажиллалаа. Нийт орлогын хэмжээ 895.5 сая төгрөг байна. Орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллаж байна.

4. Зардлын тухай :

Тус компани нь 2019 оны эхний хагас жилд 414.2 сая төгрөгийн зардалтай ажилласан. Зардлыг төлөвлөгөөнөөс хэтрүүлээгүй болно.

5. Ашгийн тухай

Компани 2019 оны эхний хагас жилд 481.3 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа.

Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл:

2019 оны 02-р сарын 18-ны бүртгэлийн өдрөөр тус компани нь 911 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд үүнээс:

- 30 хувьцаа эзэмшигчид нь гадаадын иргэд байгаа бөгөөд тэдгээр нь 2 907 743 ширхэг хувьцаа эзэмшиж, нийт хувьцаанд 3.7%-ийг,
- 881 хувьцаа эзэмшигчид дотоодын иргэд байгаа бөгөөд тэдгээр нь 75 635 258 ширхэг хувьцаа эзэмшиж, нийт хувьцаанд 96.3%-ийг эзэлж байна.

Мөн нийт хувьцаа эзэмшигчдийн:

- 92 хувьцаа эзэмшигчид буюу 10.1% нь компанийн 10 000 ба түүнээс дээш ширхэг хувьцааг,
- 819 хувьцаа эзэмшигчид буюу 89.9% нь компанийн 9 999 ба түүнээс доош ширхэг хувьцааг эзэмшиж байна.

Компанийн 4-өөс дээш багцыг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх %
1	Иргэн Д.Зоригт	42 530 145	54.14
2	Иргэн Д.Оюунсүрэн	23 460 015	29.87
3	“Импера Монголиа”ХХК	3 764 043	4.7
4	Бусад	8 788 798	11.29
Нийт дүн		78 543 001	100

Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

2019 оны эхний хагас жилд тус компанийн нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ 6 төгрөг 13 мөнгө байна. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн төлөвлөгөө 5 төгрөг 43 мөнгө байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 113%-тай гарсан. Компанийн хэмжээнд эхний хагас жилийн орлого, зарлагын төлөвлөгөөг биелүүлэн ажиллалаа.

Хаяг, холбоо барих ажилтан

1. Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 4-р хороо, Нарны зам – 20, “Гермес центр” ХК-ийн төв оффисын байр болон барилгын материалын Гермес худалдааны төв
2. Вэб хаяг: www.hermescenter.mn
3. Холбогдох утас: 976 – 11 – 30 15 77
4. Холбоо барих албан тушаалтан:
 - Нягтлан бодогч О.Энхтуяа
 - Мэргэжилтэн Д.Эрдэнэсүрэн